

ЗӨВЛӨХИЙН ТЕНДЕРИЙН УРИЛГА

1. **“Монголросцветмет” ХХК нь Зэрэгцээ алтны үйлдвэрийн технологийн гүүрийг шилжүүлэх төсөл**-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул сонирхогч эрх бүхий этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт орших Зэрэгцээ алтны үйлдвэрийн технологийн гүүрийг одоогийн байгаа газраас нь шилжүүлэх төсөл** болно.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн энэхүү зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон **бага үнийн** аргад үндэслэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоно.
4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.
5. Сонирхсон этгээд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2017 оны 3-р сарын 02-ны өдрийн 11 цаг 00 минут**-аас өмнө ирүүлнэ үү.
6. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2017 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн 12 цаг 00 минут**-д нээнэ.

**“Монголросцветмет” ХХК,
Улаанбаатар хот 51, и/х-002
Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө,
22-р хороо, “Монголросцветмет” ХХК-ийн байр,
305 тоот өрөө,
E-mail: mailbox@monros.mn
Утас/факс: +976-11-458380(ф), +976-11-458675, +976-11-453482**